



ТӨРИЙН БАНКАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.04.30 № 03/3288

танай _____-ны № _____-т

Гомдол гарсан тухай

Танай байгууллагаас зарласан ТБ/20240203233 дугаартай “Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандарт хэрэгжүүлэлтийн үйлчилгээ үзүүлэх” тендер шалгаруулалтад оролцсон “Монголын стандарт, чанарын хүрээлэн” НҮТТБ-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Монголын стандарт, чанарын хүрээлэн” НҮТТБ-ийн гомдолд тус компанийн тендерээс шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа, тендер шалгаруулалтын баримт бичиг (ТШББ)-ийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.2.6, ТШЗ 18.2.7-д заасан мэдэгдэл ирүүлээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэрийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Гомдол дурдсаны дагуу “Монголын стандарт, чанарын хүрээлэн” НҮТТБ-ын ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1.Тендер шалгаруулалтын баримт бичигт шүүхийн тусгай архивын лавлагаа буюу сүүлийн гурван жилийн хугацаанд оролцсон иргэний хэрэг, маргааны талаар шүүхийн архивын байгууллагаас холбогдох дүрэм, журмын хүрээнд гаргасан тодорхойлолт ирүүлэхийг шаардаагүй байх тул “Монголын стандарт, чанарын хүрээлэн” НҮТТБ тендерт тус тодорхойлолтыг ирүүлээгүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

2.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.2.6-д “Тендер оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд санал болгож буй үйлчилгээг гэрээний үнэ, хугацаанд багтаан үйлчилгээний тодорхойлолт, тавигдах шаардлагын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг зөвшөөрсөн, баталсан албан бичиг ирүүлнэ.” гэж, ТШЗ 18.2.7-д “Тендер оролцогч нь үйлчилгээг гүйцэтгэхэд төлөх татвар, төлбөр, хураамж, шимтгэлийг үнийн саналдаа тусгасан байх бөгөөд тусгаагүйгээс үүсэх аливаа зардлыг захиалагч хариуцахгүй болохыг баталсан албан бичиг ирүүлнэ.” гэж тус тус заасан байна.

“Монголын стандарт, чанарын хүрээлэн” НҮТТБ-ын тендерт ирүүлсэн 2024 оны 04 дүгэр сарын 09-ний өдрийн А/23-126 тоот албан бичигт “... баримт бичигт

9766006377


заасан хуваарийн дагуу гэрээ байгуулснаас хойш 7 сарын хугацаанд зөвлөх, үйлчилгээ үзүүлэхээр дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендерийг хүргүүлж байна. Үүнд: 1.Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.” гэж дурдсан байх тул ТШББ-ийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.2.6, ТШЗ 18.2.7-д заасан шаардлага хангаагүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 17/2112 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 55.10.3 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хувийг: “Монголын стандарт, чанарын хүрээлэн” НҮТТБ-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ